

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2024 оны 3 дугаар сарын 26 өдөр

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 9, 10, 12, 13, 14, 16, 21, 25 ДУГААР ХОРООДЫН НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ТУСЛАХ ЗАМ, ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН
ДААЛГАВАР**

2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү ажил нь иргэдэд эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрах, ажиллах, зорчих таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэхдээ замын хөдөлгөөнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй, аюулгүй байдлыг хангуулан ажиллах.

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1461 дүгээр захирамж.- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/154 дүгээр захирамж.
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none">- Хан-Уул дүүргийн 9, 10, 12, 13, 14, 16, 21, 25 дугаар хороодын туслах авто зам, явган зам, нийтийн эзэмшлийн тоглоомын талбай, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн цэвэрлэгээ, үйлчилгээ
3	Ажлын тоо хэмжээ	<ul style="list-style-type: none">- Хан-Уул дүүргийн 9, 10, 12, 13, 14, 16, 21, 25 дугаар хороодын туслах авто зам, явган зам, нийтийн эзэмшлийн тоглоомын талбай, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн нийт 296,461 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан тариф, дүүргийн Засаг даргын 2024 оны А/154 дүгээр захирамжаар батлагдсан давтамжийн тоогоор хийж гүйцэтгэн тухай бүр тайлагнаж ажиллана.
4	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none">- Тус зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг дүүргийн "Тохижилт, үйлчилгээний төв" ОНӨААТҮГ хариуцаж байгаа боловч Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Чиг үүрэг шилжүүлэх тухай" А/1461 дүгээр захирамжийн дагуу дүүргийн төв зам талбайн цэвэрлэгээг хариуцан ажиллаж байгаа тул тус байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүй болсон байна.- Авто зам, замын нуух, явган зам хог хаягдал, шороо ихтэй.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none">- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none">- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар

7	Төсөл гүйцэтгэх байгууллага	<ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хот нийтийн аж ахуй байх. - Тухайн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах хүний нөөц, техник хэрэгслийн хүчин чадалтай байх. - Ижил төстэй үйлчилгээг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохино. Үүнд 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг гүйцэтгэсэн байх. /Үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээ, комисс хүлээж авсан дүгнэлтийн эхээс хийсэн хуулбар/
8	Гүйцэтгэх ажлын тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> - Зам талбайн үйлчлэгчийн нэг удаагийн цэвэрлэх талбай 10000 м2-аас ихгүй байна. - Авто зам, автобусны зогсоолын цэвэрлэгээг зуны улиралд өглөөний цэвэрлэгээг 05:00-07:00 цаг, өвлийн улиралд 06:00-08.00 цагийн хооронд бүрэн цэвэрлэж авто машин, явган зорчигч саадгүй зорчих нөхцлийг хангана. - Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүй цэвэрлэгээг хийнэ. - Өвлийн улиралд хариуцсан автозамын халтиргаа гулгааг цас орсон даруйд нягтаршиж, мөстөхөөс өмнө халтиргаа, гулгаа арилгах тусгай зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэх; - Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээг дараах дарааллаар гүйцэтгэнэ. <ul style="list-style-type: none"> а. Автобусны буудлын цэвэрлэгээ, хогийн сав суллах; б. Авто замын зорчих хэсгийн дагуух цэвэрлэгээ; в. Явган хүний замын цэвэрлэгээ; г. Нийтийн эдэлбэр газрын эд хөрөнгө дээр наасан, зурсан зар сурталчилгааг хуулах, арилгах; д. Нийтийн эдэлбэр газар, гудамж, талбайн хогийн сав суллах е. Ногоон байгууламжийн түүвэр цэвэрлэгээ ё. Хайс, хашлага, архитектурын байгууламж угаах
9	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд</u></p> <ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын тухай хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” - “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, авулгүй ажиллагааны удирдамж” UCS 1704А хотын стандарт - “Орчны аюулгүй байдал UCS0001-01:2019” зэрэг бусад шаардлагатай норм дүрмүүдийг дагаж мөрдөх, биелүүлэх. - Бусад холбогдох норм, дүрэм

ХЯНАСАН:


ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТОХИЖИЛТ,
НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ТУЯАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ
АХУЙН ХЭЛТСИЙН, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ, БАЙГАЛЬ
ОРЧИН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.ЭРДЭНЭЗУЛ